

Тайлбар 1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч та Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуульд заасны дагуу аль ангилалд байгаа талаарх тодорхойлолтоо <https://burtgel.sme.gov.mn/> цахим эсхүл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас авна.

Тайлбар 2. Жижиг, дунд ангилалд хамаарах үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид Хаан, Хас, Капитрон, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банк гэсэн арилжааны 6 банкаар дамжуулан олгож буй ЛСА-ийн санхүүжилттэй “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах-II үе шаттай төсөл”-ийн жилийн 6%-ийн хүүтэй 10 жилийн хугацаатай төслийн зээлд хамрагдах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

- www.sme.gov.mn веб хуудас,
- “Жижиг дунд үйлдвэрийн газар / SME Agency of Mongolia” пэйж хуудас,
- Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар page, Дундговь Ххаа-н Газар facebook хуудсаар болон Дундговь аймгийн Засаг Даргын Тамгын газар facebook хуудас,
- “77485555-1” дугаарын утас, Аймгийн “Хүнс, хөдөө аж ахуйн газар”-ын 70592470, /холбогдох мэргэжилтэн 89249898/ дугаарын утсаар холбогдож авна уу.
- Арилжааны банкаар дамжуулан олгож буй ЛСА-ийн санхүүжилттэй “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах-II үе шаттай төсөл”-ийн зээлд хамрагдахыг төсөл хүсвэл хүлээн авах хугацаа хамаарахгүй бөгөөд зээл хүсэгч та Хаан, Капитрон, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банкуудад шууд хандана.

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
САНГИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ДЭД ХОРООНЫ ГИШҮҮНИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ**

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах дэд хороонд ажиллахыг урьж байна.

Дээрх журмын дагуу саналын эрхтэй 7 гишүүнээс 4 гишүүнийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр сүүлийн 3 жил үйл ажиллагаа явуулсан төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд төлөөлөл нь дараахь ерөнхий шаардлагыг хангасан байна: Үүнд:

- эдийн засаг, санхүү, бизнес, инженер, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
- жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт ажиллаж байсан эсхүл тухайн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлын туршлагатай;
- сүүлийн гурван жилд Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан албан тушаал хашиж байгаагүй
- сантай бизнесийн холбоогүй
- зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх;
- шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр бусдад төлөх төлбөргүй байх.

Бүрдүүлэх материал:

- Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, өөрийн намтар, ажлын туршлагын талаарх танилцуулга
- Иргэний үнэмлэхийн лавлагаа
- Төрийн албан хаагчийн анкет
- Боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэх
- Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй тухай тодорхойлолт
- Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаа
- Төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллага нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр сүүлийн 3 жил үйл ажиллагаа явуулсан талаарх танилцуулга, тайлан.

Хүлээн авах хугацаа, байршил:

Сонгон шалгаруулалтад оролцох төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллага, түүнийг төлөөлөн оролцох төлөөлөгчийн баримт бичгийг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 17:30 цаг хүртэл Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын бичиг хэрэгт ирүүлнэ үү.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

- Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар page, Дундговь Ххаа-н Газар facebook хуудсаар болон Дундговь аймгийн Засаг Даргын Тамгын газар facebook хуудсаар орж үзнэ үү.
- “Жижиг дунд үйлдвэрийн газар / SME Agency of Mongolia” пэйж хуудас,
- 70592470 дугаарын утас

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
САНГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ
ОЛГОХ ТӨСӨЛ ХҮЛЭЭН АВАХ
ТУХАЙ**

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээн авах үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс орон даяар нэгэн зэрэг авч эхэллээ.

ХХААХҮ-ийн Сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/168 дугаар тушаалаар батлагдсан хөнгөлөлттэй зээл олгох Ерөнхий нөхцөл, салбар, чиглэлийн дагуу хүлээн авах бөгөөд бичил ангилалд хамаарах жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн ирүүлсэн төслийг Жижиг, дунд үйлдвэрийн газар болон аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар сонгон шалгаруулна.

Төсөл хүлээн авах хугацаа:

Эхлэх: 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн өглөөний 08:30 цагаас

Дуусах: 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн өглөөний 08:30 цаг хүртэл

Төслийн материалыг зөвхөн www.sme.gov.mn цахимаар хүлээн авна.

Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл:

- | | |
|---|-------------------------|
| - Зээлийн зориулалт: | Үндсэн хөрөнгө оруулалт |
| - Зээлийн хугацаа: | 5 хүртэл жил |
| - Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: | 12 хүртэл сар |
| - Зээлийн хүү: | 3 хувь |

Зээл олгох салбар:

- 1.Сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр;
- 2.Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр;
- 3.Хүнсний зоорь, агуулах;
- 4.Эрчимжсэн мал аж ахуй
- 5.Гахай, тахиа, зөгийн аж ахуй
- 6.Хүлэмжийн аж ахуй-Мод, жимс, хүнсний ногооны үр үрсэлгээ
- 7.Модон шахмал хавтангийн үйлдвэр
- 8.Оёмол бүтээгдэхүүн үйлдвэр;
- 9.Ахуйн үйлчилгээний нэгдсэн төв.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн ангилал, олгох зээлийн хэмжээ

№	Ангилал*	Ажилчдын тоо	Зээл олгох хэлбэр	Борлуулалтын орлого /төгрөг/	Зээлийн хэмжээ /төгрөг/	
					доод	Дээд
1	Бичил	1-9	Сангаас шууд олгоно	0-100 сая хүртэл	20,000,000	100,000,000
				100-200 сая хүртэл	20,000,000	200,000,000
				200 саяас дээш	20,000,000	300,000,000
2*	Жижиг	10-49	Арилжааны банкаар дамжуулан “JICA-ийн санхүүжилттэй Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах-II үе шаттай төсөл”	300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл	20,000,000	800,000,000
	Дунд	50-199		1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл		